



Мэргэжил олгох түр сургалтын залуучуудын ажил эрхлэлтэнд үзүүлэх нөлөөлөл

Судалгааг гүйцэтгэсэн: Б. Алтанцэцэг, С. Амартүвшин, Д. Баярмаа, Б.Соёлмаа, Б.Цогт-Эрдэнэ

Үндсэн үр дүн

- Мэргэжил олгох сургалтын хөтөлбөр нь богино хугацаанд залуучуудын ажил эрхлэлт болон орлогыг нэмэгдүүлж байна. Гэхдээ зардлын хувьд үр ашигтай байвал л үр дүнтэй хэрэгсэл болж чадахаар байна.
- Залуучуудын дунд эрэлт ихтэй мэргэжлүүд байгааг харгалзан үзээд сургалтанд мэргэжлээр квот тогтоохгүй байх нь залуучуудын хөтөлбөрт хамрагдах түвшинг өсгөх боломжтой.
- Суралцагсад хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээлэл хүргэдэг байх нь тэдний хичээлийн ирцийг сайжруулдаг бөгөөд сургалтаа орхих магадлалыг бууруулах зардал багатай арга байж болно.

Мэргэжил олгох сургалт

Монгол Улсын тулгамдсан асуудлуудын нэг нь ажилгүйдэл, ялангуяа залуучуудын дунд ажилгүйдлийн түвшин өндөр байгаа явдал юм. Төрөөс 2015 онд залуучуудын ажилгүйдлийн түвшинг 2.5% болгож бууруулах зорилт тавин ажиллаж ирсэн ч энэ үзүүлэлт өндөр хэвээр, тухайлбал, 2014 онд 17.4% байна. Түүнчлэн, 15-аас 25 насны залуучуудын дөрөвний нэг нь ажил хийдэггүй бөгөөд ямар нэгэн сургалт эсвэл боловсролд хамрагдахгүй туйлийн идэвхгүй байна. Ялангуяа, эцэг эх нь ажилгүй, доогуур боловсролтой, ядуу өрхөд идэвхгүй залуучууд их байна.

Монгол Улсын хүн ам харьцангуй залуу бөгөөд 54.5% нь 30-аас доош насны залуучууд юм. Иймд, залуучуудын ажил эрхлэлт аль ч Засгийн газрын үед эн тэргүүнд тавигддаг. 2003 онд, төрөөс богино хугацаат мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих идэвхтэй бодлогуудын хамгийн ууган бөгөөд хамгийн том нь юм.

Мэргэжил олгох сургалтанд хот, хөдөөгийн ажилгүй, ажилгүй болох эрсдэлтэй, албан боловсролд хамрагдаагүй залуучууд болон бага орлоготой иргэд хамрагдах боломжтой. Хөдөлмөрийн яамны мэдээлснээр 2011 онд энэ хөтөлбөрт 8000 хүн хамрагдсан байна.



Уг хөтөлбөрийн нэг гол зорилтот бүлэг нь ажилгүй залуучууд бөгөөд үсчин, тогооч, өрлөгчин, цахилгаанчин зэрэг 53 мэргэжлээр сургалт зохион байгуулдаг. Сургалт 20-иос 45 хоног үргэлжилдэг бөгөөд сургалтын агуулгад онолын сургалтаас гадна дадлага багтдаг.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын талаар хийсэн судалгаа ховор байдаг бөгөөд мэргэжлийн сургалтын залуучуудын ажил эрхлэлтэд үзүүлдэг нөлөөг хэмжсэн судалгаа одоогоор байхгүй байна. МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн судалгааны баг мэргэжлийн сургалтын залуучуудын ажил эрхлэлт, ажлын чанар болон орлогод үзүүлж буй нөлөөг Улаанбаатар хотод хэрэгжиж буй хөтөлбөр дээр үнэлсэн нь энэ чиглэлээр хийгдсэн анхны судалгаа юм.

Нөлөөллийн үнэлгээний судалгаа

МУИС-ийн судлаачдын баг Нийслэлийн хөдөлмөрийн газартай хамтран мэргэжил олгох сургалтын хөтөлбөрийн үнэлгээг амжилттай гүйцэтгэж дууслаа. Судалгаанд хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ гаргасан 15-аас 30 насны ажилгүй залуучуудыг хамруулсан бөгөөд эдгээр оролцогчдыг санамсаргүйгээр сургалтанд хамрагдах бүлэг (774), хамрагдахгүй буюу хяналтын бүлэг (414) болгон хуваарилсан. Сургалтад хамрагдсан 410 хүнээс 119 нь зөвхөн сургалтад хамрагдсан бол 291 хүнд Монголын хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл нэмж өгсөн.

Судалгааны баг гурван удаагийн түүвэр судалгаа хийсэн бөгөөд сургалт эхлэхээс өмнө нэг суурь судалгаа, сургалтын дараа хоёр удаагийн мөшгөх түүвэр судалгаа хийсэн. Эхний мөшгөх судалгаа нь сургалт дууссанаас хойш 6 сарын дараа, харин хоёр дахь мөшгөх судалгаа нь нэг жил хагасын дараа хийгдсэн. Судалгаа нь сургалтанд хамрагдах болон хамрагдахгүй (хяналтын) бүлгийн залуучуудын ажил эрхлэлт, цалин, болон сургалтанд бүрэн хамрагдалтад гарсан өөрчлөлтүүдийг харьцуулах замаар үнэлгээг хийсэн.

Судалгааны гол үр дүн

Мэргэжил олгох сургалтын хөтөлбөр нь богино хугацаанд дараах нөлөөтэй:

- Ажил эрхлэлтийг 13 хувиар нэмэгдүүлдэг
- Цалинг 25 хувиар өсгөдөг
- Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах магадлалыг 4 пунктээр өсгөдөг.

Сургалт дууссанаас хойш 6 сарын дараа 25-30 настай оролцогчдын ажил эрхлэлт нь бусад насны бүлгүүдтэй харьцуулахад илүү өндөр байх хандлагатай байжээ.

Дунд хугацаанд, мэргэжил олгох сургалт цалинг 16 хувиар өсгөдөг боловч ажил эрхлэлт болон эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломжид нөлөөлдөггүй байна.

Судалгааны үр дүнгээс харахад сургалтын ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө нь эрэгтэй, эмэгтэй оролцогчдын хувьд ялгаагүй байна. Богино хугацаанд, гэр хороололд амьдардаг оролцогчдын ажил эрхлэлт нь орон сууцанд амьдардаг залуучуудтай харьцуулахад илүү өндөр байжээ.

Харин сургалтад хамрагдсан бөгөөд орон сууцанд амьдардаг оролцогчид гэр хороололд амьдардаг оролцогчидтой харьцуулахад 2%-иар илүү мэргэжлээрээ ажиллах магадлалтай байна.

Сургалт болон хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл авсан оролцогчид зөвхөн сургалтанд хамрагдсан оролцогчдоос илүү идэвхтэй (3.3 өдрөөр) сургалтандаа хамрагддаг бөгөөд сургалтаа орхих магадлал нь 5%-иар бага байгаа нь бусад судалгааны үр дүнтэй нийцэж байна. Тухайлбал, судалгаанд оролцогчид боловсрол болон сургалтын үр өгөөжийг бодит байдлаас хэт доогуур үнэлдэг бөгөөд энэ нь сургалтанд хамрагдалтыг бууруулж, улмаар сургалтаа орхих магадлалыг нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлтэнд Женсен (2010) хүрчээ.

Бодлогын зөвлөмж

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн мэргэжил олгох сургалт нь богино хугацаанд залуучуудын ажил эрхлэлтийн нэмэгдүүлж, орлогыг өсгөх үр ашигтай бодлогын хэрэгсэл гэж дүгнэж байна. Гэхдээ цаашид хөтөлбөрийг илүү үр дүнтэй болгохын тулд сайжруулах шаардлагатай зүйлс байна. Тухайлбал, хэмжээний хувьд харьцангуй жижиг, богино хугацаатай энэ хөтөлбөрийг агуулга болон захиргааны шаардлагынх нь хувьд дахин хянаж сайжруулах шаардлагатай.

Тухайн үед хөтөлбөрийн зохицуулалт ёсоор мэргэжил бүр дээр тодорхой квот тогтоож байсан. Гэтэл зарим мэргэжлүүд залуучуудын дунд эрэлт ихтэй байдгаас тухайн мэргэжлийн квот дууссанаар сонирхсон залуучууд хөтөлбөрт хамрагдахгүй хоцроход хүрч байлаа. Нэн ялангуяа, үсчин, гоо сайхан, тогооч, худалдагч, кассын нярав болон цэцэрлэгийн туслах багш гэсэн мэргэжлүүд хамгийн өндөр эрэлттэй байсан юм. Ингэж квот тогтоохыг болиулснаар залуучуудын сургалтын хөтөлбөрт хамрагдах түвшинг өсгөх боломжтой юм.

Эцэг эх нь доогуур боловсролтой, ядуу өрхийн залуучууд нь ажилгүйдэлд өртөх эрсдэл өндөртэй байдаг. Иймд сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээг амьжиргааны түвшин доогуур, мөн боловсрол багатай өрхийн залуучууд гэсэн сургалтанд хамрагдах хэрэгцээ ихтэй бөгөөд сургалтаас хамгийн их үр ашиг хүртэх бүлэгт чиглүүлэх нь илүү үр дүнтэй.

Сургалтанд хамрагдагдахаас гадна хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээлэл авсан залуучуудын хичээлийн ирц сайн бөгөөд сургалтаа орхих магадлал бага байсан нь суралцагсад ийм төрлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх нь хөтөлбөрийн нөлөөг нэмэгдүүлэх зардал багатай арга байж болох юм.